



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

10 21 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 02

Даланзадгад

┌ Төрийн албаны ёс зүй, сахилга, ┐
хариуцлагыг сайжруулах талаар авах
зарим арга хэмжээний тухай

Авлигатай тэмцэх газраас 13 яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, 27 агентлагийн хүрээнд “Шударга байдлын үнэлгээ”-гээ хийдэг бөгөөд тус үнэлгээгээр Өмнөговь аймаг нь 2018, 2019 онд хангалтгүй үнэлэгдсэн нэг шалтгаан нь төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлага, хүнд суртал, харилцаа хандлагатай холбоотой байна.

Иймд орон нутаг дахь төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлага, хүнд суртал, харилцаа хандлагыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт ДААЛГАХ нь:

1.Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан нь өөрийн байгууллагад Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, хариуцсан салбар, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж төрийн албан хаагч Төрийн албаны тухай хууль болон ёс зүйн дүрмээр хүлээсэн хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх

2.Албан хаагчдын ажлыг цаг ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, төрийн албаны стандарт, соёл, дэг журмыг байгууллагадаа мөрдүүлж хэвшүүлэх

3.Төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ иргэдийг ялгаварлан гадуурхахгүй, шударга байх, төрийн албыг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, мөн иргэдэд тийм сэтгэгдэл төрүүлэх үйлдэл болон үг хэллэг ашиглахгүй байж иргэдтэй эелдэг харьцан, иргэнд хүнд суртал, чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх

• 462210003

2.

4.Төрийн албаны тухай хууль болон ёс зүйн дүрэм зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан хаагчид хариуцлага тооцон энэ талаар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тайлагнаж хэвших

5.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Т.Дөлбаяр/, зохион байгуулсан ажил арга хэмжээ, гарсан үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад тайлагнахыг Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга /С.Баярнасан/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.СЭДДОРЖ